

EMBX- ЕВРОПЫН МОНГОЛЧУУДЫН ВОЛЕЙБОЛЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ Х ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Европ дахь монголчууд болон өсвөр үеийн хүүхэд залуусыг волейболын спорт руу уриалан дуудах, уг спортоор хичээллэх сонирхол төрүүлэх, Европын монголчууд спортоор нөхөрлөж ойртон танилцаж бие биенээсээ харилцан суралцах боломж бүрдэх зорилгоор зохион явуулагдаж ирсэн Европын Монголчуудын аварга шалгаруулах Х тэмцээнийг зохион явуулахад баримтлан мөрдөх заавар болно.

2. ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Белгийн монголчуудын СҮЛД холбоо

Цахим шуудангийн хаяг: suldhoolboo@gmail.com

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Европ дахь Монголчуудын Волейболын Холбоо (EMBX),

Цахим шуудангийн хаяг: euromongolvolley@gmail.com

Website: <https://www.euromongolvolley.com>

3. ТЭМЦЭЭНИЙ ХУВААРЬ

Тэмцээн: 2024 оны 11-р сарын 1-3-ны өдрүүдэд болно./ Нийт 3 хоног /

4. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ХОТ, ТЭМЦЭЭН БОЛОХ ГАЗАР

Бельги улсын Herentals хотын Sport Vlaanderen Herentals спорт цогцолбор

Vorselaarsebaan 60, 2200 Herentals

5. ТЭМЦЭЭНИЙ АНГИЛАЛ, БАГУУДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. Тэмцээн насанд хүрэгчид, мастер (ахмад) гэсэн хоёр ангилалаар явагдана.

Насанд хүрэгчид: Эмэгтэй 16-аас дээш, Эрэгтэй 16-аас дээш (*Тухайн тэмцээнд баг, клубд хичээллэдэг 16 гаас доош өсвөр насны хүүхэд оролцох бол эцэг эхийн зөвшөөрлийг үндэслэн оруулцуулж болно.*)

Мастер (Ахмад): Эмэгтэй 36 нас ба түүнээс дээш

Эрэгтэй 40 нас ба түүнээс дээш

5.2. Европын улс орнуудад суугаа Монголчуудын холбоо клуб, багуудаас болон

Европын холбооны улсад одоо байнгийн оршин сууж байгаа тоглогч байна ((3 сараас дээш хугацаагаар) /Оюутан, гэрээгээр ажиллаж буй/. Тамирчид нь оршин суугаа улсаасаа өөр улсын багт тоглохыг зөвшөөрнө.

5.3. Зохион байгуулагчид нь тоглогчийн холбогдох бичиг баримтыг үндэслэн шалгаж тэмцээнд оролцох мандатыг олгоно.

5.4. Тоглогчид Европын холбооны улсад 3 сараас дээш хугацаагаар амьдарсан байх ёстой.

5.5. Техникийн зөвлөгөөний үеэр болон зооны эхний тоглолт дуусахаас өмнө эсрэг багийн гаргасан хүсэлтийн дагуу аль нэг тоглогчийн бичин баримыг шалгах эрхтэй.
Үүнд: Насны ангилалд багтаж буй эсэх, Европын холбооны улсад одоо байнгийн оршин сууж байгаа эсэх. Тухайн тэмцээний ДЭЭРХ нөхцлийг зөрчсөн нь тогтоодвол, эсхүл нотлох баримтаа үзүүлээгүй тохиолдолд уг тоглогчийг тэмцээнээс хасаж, тухайн тоглолтын хожлыг эсрэг багт олгож болно. Шийдвэрийг Ерөнхий шүүгч болон зохион байгуулагч комисс хамтран гаргана.

6. БАГИЙН МЭДҮҮЛЭГ БА МЭДЭЭЛЭЛ

6.1. Оролцох багууд 2024 оны 10-р сарын 01-ний дотор албан ёсны мэдүүлгийг euromongolvolley@gmail.com цахим шуудангийн хаягаар илгээнэ. Үүнд:

а) Багийн мэдүүлэг /маягт MVA0103002/

Маягт татаж авах хаяг :

<https://www.euromongolvolley.com>

МВХ-ны Европ дахь салбар Холбоо (Facebook Page)

б) Баг түүний бүрэлдэхүүний тухай /маягт MVA0103003/

Маягт татаж авах хаяг :

<https://www.euromongolvolley.com>

МВХ-ны Европ дахь салбар Холбоо (Facebook Page)

в) Онлайнаар нягтрал сайтай цээж зураг ирүүлэх / хүн тус бүр, баг/

6.2. Техникийн зөвлөгөөн дээр эцсийн мэдүүлгийн эх хувийг авч ирж баталгаажуулна.

7. ТОГЛОЛТЫН ОНООЛТ, ШҮҮЛТ

- 7.1. Тэмцээнийг ОУВХ-ны тоглолтын дүрмийн дагуу болон EMBX-ны “Тэмцээн зохион байгуулах журмын” дагуу явуулна.
- 7.2. EMBX-ноос томилогдсон шүүгчид тэмцээнийг шүүнэ.
- 7.3. Оролцогч багуудын тооноос хамаарч тоглолтын системийг техникийн зөвлөгөөн дээр шийдвэрлэнэ. Сугалааны үр дүнг үндэслэн тоглолтын дараалал (кодекс) техникийн зөвлөгөөний дараа тодорхой болно.
- 7.4. Багуудын тоглолтын хувиарь өөрчлөгдсөн бол цаг тухайд нь буюу тоглолтоос багадаа 30 минутын өмнө мэдээллийн самбарт мэдээлсэн байна. /Мэдээллийн самбар байрлах цэгүүдийг байрлалыг Техникийн зөвлөгөөний үеэр мэдээлнэ./
- 7.5. Тоглолтууд 3 үеэр үргэлжилнэ. Эхний 2 үед нэг баг хожлыг авсан бол 3 дахь үеийн явуулахгүй дуусгавар болгоно. Албан ёсны бие халаалтын цаг 10 минут байна.
- 7.6. Тоглолтын дүн гаргахдаа хамгийн олон оноо авсан баг нь тэргүүлэх эрэмбийг баримтлана. Хэрвээ баг тоглолтын явцад эрхээ хасуулбал тэмцээнээс хасагдах бөгөөд өмнөх тоглолтын бүх үр дүнгүүдийг тэглэнэ. Эсрэг тоглосон багуудыг тухайн тоглолтын ялагч гэж үзнэ.
- 7.7. Тэмцээнийг MIKASA Volleyball MVA200 маркийн бөмбөгөөр явуулна. Бие халаалтын бөмбөгөө багууд өөрсдөө авч ирсэн байна.

8. БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- 8.1. Баг тус бүр 12 гишүүнтэй байна. Үүнд: 10 тоглогч, багийн эзэн/менежер - 1, дасгалжуулагч 1 байна. / Жич: EMBX-д багуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу энэ удаагийн 10-р тэмцээнд дасгалжуулагч болон менежер өөрийн багт тоглохыг зөвшөөрөв./
- 8.2. Багууд албан ёсны гэрчилгээ бүхий дагалдах шүүгчтэй ирэхийг эрмэлзэнэ. Тухайн шүүгч нь тэмцээн шүүгчдийн бүрэлдхүүнд орох, өөрийн багаас бусад багуудын тоглолтыг шүүх ба тэмцээний кодекс гаргах зэрэг асуудалд хамтран ажиллах боломжтой.
- 8.3. Талбай дээр заавал 6 тоглогч байх ОУВХ дүрмийг баримтлана. Аль нэг тоглогч тодорхой шалтгааны улмаас /бэртэл гэмтэл, зөрчил/ тоглолтыг орхиж талбай дээр 5 тоглогч үлдвэл тоглолтыг зогсоож эсрэг багт хожсонд тооцно. Иймд багууд нөөц тоглогчидтой ирэхийг эрмэлзэнэ.
- 8.4. Ахмад ангилалд тоглож буй нэг багийн 1-2 тоглогч насанд хүрэгчдийн ангилалд зөвхөн өөрийн баг, клубын нэг багт шилжин тоглохыг зөвшөөрнө. (Мэдүүлэгт нэр нь тусгагдсан байна).

9. ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН

9.1. Техникийн зөвлөгөөн 10-р сарын 31-ний 19:00 цагт эхлэнэ.

Хаяг : Бельги улсын Herentals хотын Sport Vlaanderen Herentals спорт цогцолбор /
Vorselaarsebaan 60, 2200 Herentals

9.2. Техникийн зөвлөгөөн дээр багийг төлөөлөх эрх бүхий менежер, дасгалжуулагч, ахлагч нар оролцоно.

9.3. Техникийн зөвлөгөөнийг Олон улсын волейболын холбооны дүрмийн дагуу удирдан явуулна.

10. ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БА ХЯНАЛТ

10.1. Тэмцээний туршид ажиллах эмчийг Зохион байгуулах комисс томилно. Анхны яаралтай тусламжийг яаралтай үзүүлэх боломж нөхцлийг зохион байгуулах комиссоос хангасан байна.

10.2. Баг нь бүх гишүүдийнхээ эрүүл мэндийг даатгалыг хариуцна.

11. ХУВЦАС

11.1. Тоглолтын хувцас ОУВХ-ны стандартад нийцсэн байна. Баг тамирчид жигд, тоглолтын 2 ээлжийн хувцастай байна. Мөн зөвхөн мэдүүлэгт баталгаажуулсан дугаар бүхий хувцасыг өмсөнө.

11.2. Хувцасыг буруу өмсөх, стандартыг дагаж мөрдөөгүй тохиолдолд дүрмийн дагуу торгууль хүлээнэ. (ОУВХ-ны Тэмцээн зохион байгуулах дүрмийн 19.5 дагуу)

11.3. Хажуугийн сандал дээр зөвхөн тухайн багын тамирчдаас гадна дасгалжуулагч, багийн менежер сууж болно. Албан ёсны хувцас өмсөөгүй бол багийн гишүүдтэй ойртохыг хориглох ба багийн гишүүдтэй ижил хувцас өмссөн тохиолдолд харилцаа үүсгэж болно.

12. ХАРИУЦЛАГА ЁС ЗҮЙ

12.1. Тэмцээнд оролцож байгаа бүх оролцогчид спортын шудрага өрсөлдөөнийг эрхэмлэн Олон улсын Волейболын холбооны холбогдох журмуудыг ёсчлон мөрдөнө. Энэ талаар Техникийн зөвлөгөөний үеэр мэдээлэл хүргэнэ. Багийн удирдлагууд багийн тамирчдад энэхүү зааврыг болон тэмцээн зохион байгуулах журмыг танилцуулсан байх үүрэгтэй.

12.2. Тэмцээнд оролцох мандат авсан эрх бүхий этгээд согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдолд ямар нэгэн үүрэг гүйцэтгэх эрхийг шууд түтгэлзүүлнэ.

12.3. Тамирчны ёс зүйг үл дээдлэх үйлдэл гаргаж, зохион байгуулалтад хүндрэл учруулах зөрчлийг зохион байгуулах комисс таслан зогсоох арга хэмжээ авна.

13. ТЭМЦЭЭНИЙ ХУРААМЖ, ЗАРДАЛ

13.1. Баг тус бүр дараах хураамж төлнө:

- а) Х тэмцээний хураамж баг тус бүр 250€ евро.
- б) EMBX гишүүнчлэл тамирчин тус бүр 5€

Тодруулга тайлбар:

6 гишүүн бүхий баг $250 + 6 * 5 = 280$ €

8 гишүүн бүхий баг $250 + 8 * 5 = 290$ €

10 гишүүн бүхий баг $250 + 10 * 5 = 300$ €

12 гишүүн бүхий баг $250 + 12 * 5 = 320$ €

Нэмэлт мэдээлэл: EMBX гишүүнчлэлийн хураамж нь MBX-ны гишүүнчлэлийн лицензийн төлбөр болон жил болгоны уламжлалт тэмцээн зохион байгуулахад цом, медаль, шүүгч гэх мэт зардалд дэмжлэг үзүүлэх болон холбооны тогтвортой үйл ажиллагааны зардал, EBX-ны тэмцээний хуримтлал үүсгэхэд зарцуулагдана.

13.2. Зохион байгуулах комисс дараах зардлуудыг хариуцна:

- а) Тэмцээний заалны түрээс болон шүүгч, зохион байгуулалтын зардал
- б) Шагнал урамшуулал, Мэдээлэл сурталчилгааны зардал
- в) Эмнэлгийн анхны тусламж

14. ШАГНАЛ

14.1. Эхний 3 байр эзэлсэн багуудад Зохион байгуулах комиссоос цом, медаль мөнгөн шагнал, олгоно.

14.2. Медалийг 10 тамирчин, 1 дасгалжуулагчид, 1 багийн менежерт олгоно.

14.3. Тэмцээний статистикийг үндэслэн хамгийн шилдэг тоглогчдод тусгай шагнал олгоно. Үүнд:

- о Тэгш тоглогч/MVP/
- о Довтлогч
- о Холбогч
- о Хамгаалагч
- о Өсөх ирээдүйтээ тоглогч

15. МАРГААН

15.1. Тухайн тоглолт дууссанаас 30 минутын дотор багийн менежер эсвэл дасгалжуулагч нь гомдол гаргах эрхтэй. Багын ахлагч, дасгалжуулагчид тоглолтыг зөвшөөрч тэмцээний протоколд гарын үсэг зурсан тохиолдолд гомдолыг хүлээж авахгүй.

15.2. Тоглолтын маргаантай асуудлыг Ерөнхий шүүгч, тоглолтын бус үед гарсан маргаантай асуудлыг Зохион байгуулах комисс хэлэлцэж 30 минутын дотор

шийдвэрлэнэ.

- 15.3. Гомдол гаргагч 50€ барьцаа тавьж гомдлоо бичгээр гаргах ба хэрэв гомдол үндэслэлтэй гэж үзвэл уг барьцааг буцаан олгоно. Гаргасан гомдол нотлогдохгүй бол уг барьцаа Зохион байгуулах Комисст үлдэнэ.

16. БУСАД ЗҮЙЛ

- 16.1. Зохион байгуулагч нь хэвлэл мэдээлэл, ТВ-ийн нэвтрүүлгээр тоглолтын дамжуулах болон тоглолтын үеийн зургийг хэвлэн нийтлэх эрхтэй.
- 16.2. Энэхүү зааварт тусгагдаагүй бусад асуудлыг Европын Монголчуудын Волейболын холбооны тэмцээний журамд (<https://www.euromongolvolley.com/>) заасны дагуу Зохион байгуулах комисс өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэгдэнэ.

ЕВРОП ДАХЬ МОНГОЛЧУУДЫН ВОЛЕЙБОЛЫН ХОЛБОО (EMBX)